

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
**/2022.02.28-2022.03.04/**

2022.03.04

Дархан хот

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилгын чиглэл	Иргэн Г.Галавсэнгийн хүсэлтийн дагуу Дархан сум, 9-р багт байрлалтай автомашины гаражийн зориулалттай газарт барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн тухай бичиг баримттай танилцаж газрын зориулалтын дагуу биш байсан тул албан бичгээр хариуг өгсөн. Барилга байгууламжийн норм, нормативын сан"-ийн үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөнд тусгуулсан "Барилга байгууламжийн эзлэхүүн, барилга байгууламж барих эдэлбэр газрын харьцааг тодорхойлох аргачлал"-ын дүрмийн техникийн даалгавар төсөлд саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.
2	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	Шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажлын хэсгийн хуралд оролцов "Ногоон Дархан 2032" хөтөлбөрийн мод тарих, үржүүлэх газрын байршлын зураг "Ногоон Дархан 2032" хөтөлбөрийн ажлын хэсгийн хуралд
3	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал	- Нөхөн бүрдүүлэлтийн 52 иргэний өргөдлийг ажлын талбартай нь холбосон.
4	Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан	2022.02.25-нд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка төслөөс зохион байгуулсан Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны мөчлөг ба өндөрт ажиллах үеийн аюулгүй ажиллагаа сэдэвтэй 8 цагийн сургалтанд хамрагдан гэрчилгээ авсан.
<b>Газрын удирдлагын хэлтэс</b>		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	5 иргэнд "Газрын төлөв байдал чанарын хянан баталгааны мэдэгдэх хуудас" хэвлэж өгсөн. Захиалгат хянан баталгааны 10 тайланг Газрын мониторингийн системд хянаж баталгаажуулсан, 1 тайланг хянаж буцаасан.
2	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөлийн чиглэл	Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 9 албан бичгийн лавлагааг мэдээллийн сан болон газар өмчлөх захирамжаас шүүж хариуг хүргүүлсэн. Дархан сумын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж аваагүй тухай лавлагааг нийт 6 иргэнд гаргаж өгсөн. 2021 оны ТСШ-аар олгосон нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн гэрээ, гэрчилгээг цахим системд үүсгэсэн нийт 11 нэгж талбар үүсгэсэн. <b>Нэмэлт ажил:</b> Эцэг, эхийн зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын тайланг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн.

3	Газрын төлбөр, татвар, үнэлгээ	Дотоод Аудитын хорооны хорооны 2022.02.16-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллаж байна. Газрын төлбөрийн зөрүүтэй Петрожамп ХХК-ий 9668414 төгрөгийг СХААлбаны актын төлбөрийн орлогын 10019000986 дансанд 2022.03.02-ний өдөр бүрэн төлүүлж барагдуулж ажиллаа. Алтан хүнс групп ХХК нь газрын төлбөрийн зөрүү 15.3 сая төгрөгийг 2022.04-2022.08 сар дуустал сард 3061435 төгрөгийг төлж дуусгахаар хуваарь гарган 2022.03.01-ний өдрийн А/07 тоот албан бичиг, Нано металл ХХК нь газрын төлбөрийн зөрүү 3.9 сая төгрөгийг 2022.03-2022.10 сар дуустал сард 500000 төгрөгийг төлж дуусгахаар хуваарь гарган 2022.02.28-ний өдрийн 01 тоот албан бичгийг СХАА-д болон манай байгууллагад тус тус хүсэлт ирүүлсэн байна.
<b>Захиргаа удирдлага</b>		
1	Хүний нөөц, хууль эрх зүйн чиглэл	<p><b>Сургалт:</b> 2022.03.03-ны өдөр Суурь судалгаа, газрын мониторинг хариуцсан мэргэжилтэн Агентлагаас зохион байгуулсан Мониторингийн цахим системд хэрхэн ажиллах талаарх цахим сургалтанд хамрагдсан. /zoom/</p> <p>- 2022.03.03-нь өдөр Хот байгуулалт, төлөвлөлт магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Дарьсүран нь Urban.gov.mn кадастрын системийн сургалтад суусан.</p> <p>-2022.03.04-ны өдөр “Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөж буй тодорхой асуудал” хэлэлцүүлэгт zoom meeting хүний нөөцийн мэргэжилтэн Б.Золбаясах холбогдож оролцов.</p> <p><b>Хүний нөөц:</b> “ Байгууллагын дотоод журам”-аа шинэчлэхээр албан хаагчдаас санал авч тусган боловсруулхаар ажиллаж байна. Энэ 7 хоногт 1 албан хаагч эмнэлэгт, 1 албан хаагч чөлөө авсан.</p> <p><b>Үүрэг даалгавар:</b> Аймгийн ЗДТГ-аас төрийн байгууллагуудад өгсөн сар бүрийн эхний 7 хоногт бүх нийтийн цэвэрлэгээгээр байгууллагын ойр орчны хог, цасыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна.</p>
2	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b> Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 70376471 нээлттэй утсаар 2, Facebook хуудсанд иргэн, ААНБ-аас асуусан 3 асуултанд хариулт өгөв. 2022-03-03-нд Цахим төвд жижүүрлэн газартай холбоотой хүсэлт өгөхөөр ирсэн иргэдэд Газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллав.</p> <p><b>Мэдээлэл технологийн чиглэлээр:</b> Байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсний Санхүүгийн мэдээ хэсэгт 2022 оны 1, 2-р сарын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 2021 оны санхүүгийн тайлан, “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээллийг байрлуулав. Ил тод байдал цэсний Хүний нөөц хэсгийг 3 хэсэг болгож хуваан мэдээлэл нэмж оруулав. Санал гомдол хүлээн авах хэсгийн кодыг шинээр бичиж, тестлэн ажиллагаанд оруулав. Байгууллагын Фэйсбүүк хуудсан дээр “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд ГХБХБГ-ын хамт олон нэгдсэн тухай мэдээллийг байрлуулав.</p> <p><b>Нярав:</b> Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 8 ширхэг Нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов. Шаардах хуудсаар 18 төрлийн 341 ширхэг бараа материал олгов. 2-р сарын үнэт цаас, улсын тэмдэгтийн хураамж, бараа материалын зарцуулалтын тайланг нэгтгэж ня-бод өгөв. 2021 оны газар эзэмших, ашиглах гэрчилгээ /ААНБ, ТБ/ зарцуулалтын тайлан, ААНБ-ын Улсын тэмдэгтийн хураамжийн тайланг үдэж, хавтаслан, хуудсыг дугаарлаж архивт хүлээлгэн өгөв.</p>

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж